



СЭЛЭНГЭ АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

Аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

“СЭЛЭНГЭ ЗҮҮНХАРАА” ОНӨААТҮГ-ЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН



Ерөнхий дүгнэлт

“Сэлэнгэ Зүүнхараа” ОНӨААТҮГ -ын удирдлага, менежмент, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа туйлын хангалтгүй болон дотоод хяналт үр нөлөө муутайгаас шалтгаалан үр ашиггүй, алдагдалтай ажиллаж байна.

Сүхбаатар сум
2016 он

<u>Тайланг бэлтгэсэн:</u> ҮАГ-ын харьяа Сэлэнгэ аймгийн Аудитын газар Тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа Аудитын менежер Б.Батмөнх Аудитор Ц.Отгонбаяр 2016 оны 06 сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70362442 дугаарын утас, 70363040 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ:Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум, аймгийн ЗДТГ- ын байрны Өргөтгөлд	ТАЙЛАНГИЙН АГУУЛГА Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй Хоёр. Үндсэн мэдээлэл Гурав. Аудитын дүн - ОНӨААТҮГ- уудын үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу. - Үйл ажиллагаа нь холбогдох хууль эрхийн актын хүрээнд үр нөлөөтэй хэрэгжиж байна уу - Үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнгийн тайланг ТУЗ болон холбогдох бусад байгууллагаар хэлэлцэж үнэлэлт, дүгнэлт өгөгдөж байна уу. - Үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байна уу. - ОНӨААТҮГ-ууд нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу. - Үйл ажиллагааны орлогыг бүрэн дүүрэн, үндэслэлтэй төлөвлөн төвлөрүүлж байна уу. - Төвлөрсөн орлогыг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулж байна уу - Авлага, өглөгийг барагдуулж, үр ашигтай ажиллаж байгаа эсэх. - Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу. - Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, эрхийн актын хүрээнд зохион байгуулж байна уу - Хөрөнгө нөөцийг хэрэгцээ, шаардлагын хэмжээнд бэлтгэн, ашиглаж байна уу - Хөрөнгийг бүртгэл тооцоонд бүрэн тусгаж, тооллого, тооцоог цаг хугацаанд нь гүйцэтгэж байна уу. Дөрөв. Илрүүлсэн зөрчил Тав. Аудитын дүгнэлт Зургаа. Зөвлөмж Холбогдох байгууллагын санал: Саналд өгсөн тайлбар
---	---

Товчилсон үгийн тайлбар

МУ	Монгол улс
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИТХТ	Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчид
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах
ТБОНӨ	Төрийн болон орон нутгийн өмч
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ОНӨА	Орон нутгийн өмчийн алба
СББ	Спирт бал бурам
УБТЗ	Улаанбаатар төмөр зам
ЭХУХ	Эрчим хүч ус хангамж

Нэг. Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур үзүүлэлтүүд

1. Аудитын нэр: “Сэлэнгэ Зүүнхараа” ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны үр дүн.

2. Аудитын код: СЭАГ-2016/01-ГА

3. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аймгийн Аудитын газрын 2016 оны бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн МУ-ын Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

4. Аудитын зорилт:

Сэлэнгэ аймгийн орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтнуудад танилцуулахад аудитын зорилт оршив.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаа нь холбогдох хууль, эрхийн актын хүрээнд, үр нөлөөтэй хэрэгжиж байна уу?
- Орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд нь орлого, зарлагаа үндэслэлтэй төлөвлөж, үр ашигтай ажиллаж байна уу?
- Хөрөнгийн худалдан авалт, ашиглалт, зарцуулалт арвилан хэмнэлт, үр ашигтай байна уу?

5. Аудитын хамрах хүрээ:

Аудитаар 13 орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүдээс “Сэлэнгэ Зүүнхараа” ОНӨААТҮГ-ын 2015, 2016 оны 1-5 сар хүртэлх үйл ажиллагаатай холбоотой гаргасан сумын ИТХ-ын тогтоол шийдвэрүүд, тус ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, санхүүгийн баримтуудыг хамруулав.

6. Аудитын арга зүй:

Аудитын явцад Төрийн хяналт шалгалтын стандартыг мөрдөж, Гүйцэтгэлийн аудитын удирдамж (АДБОУС 3000-3100)-ийг ашиглан Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ-ын дарга, нягтлан бодогч, мэргэжилтнүүдтэй ярилцлага хийн, асуулга лавлагаа, тодруулга авч, байгууллагын үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, бусад шаардлагатай баримт материалд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулан, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

7. Аудитад ашиглах хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт:

Аудитад ОНӨААТҮГ-ын батлагдсан төсөв, гүйцэтгэл, тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг шалгуур үзүүлэлт болгохоос гадна дараах үзүүлэлтийг шалгуур болгон ашиглалаа. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ТБОНӨХБАҮХАТ хууль
- ААНОАТ-ын тухай хууль
- НӨАТ-ын тухай хууль
- Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай
- Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрх зүйн актууд болон МУ-ын Сангийн сайдын 2012 оны 77-р тушаал, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 104 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам”, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 45 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрэм”

8. Аудит хийх бүрэлдэхүүн:

Аудитыг Сэлэнгэ аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа удирдаж, аудитын менежер Б.Батмөнх явцын болон чанарын хяналтыг гүйцэтгэн, аудитор Ц.Отгонбаяр 2016 оны 05 дугаар сарын 18-ны өдрөөс 06 дугаар сарын 28-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

ХОЁР.ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Мандал сумын Сэлэнгэ-Зүүнхараа ОНӨААТҮГазар нь 2006 оны 04-р сарын 10-нд байгуулагдаж дулаан үйлдвэрлэх, дулаан түгээх, мах бэлтгэх төв, орон сууц ашиглалт, зам засвар гэсэн 4 чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Мандал сумын ИТХ-ын 2013 оны 45 дугаар тогтоолоор тус үйлдвэрийн газрын дүрмийг батлан, захирлаар нь Т.Эрдэнэтуяаг томилсон байна.

ОНӨААТҮГ нь БЗИУ -100 маркийн уурын даралтад тогоо-4, өөрийн зуухнаас 66 аж ахуйн нэгж, 90-ээд айл өрхийг дулаанаар хангахын зэрэгцээ УБТЗ-ын ЭХУХ-ын 1-р ангийн цэвэр ус, СББ ХХК-ны дулаан, халуун, хүйтэн усыг Тост өргөө хотхоны 100-н айл, 10-н аж ахуйн нэгжид дамжуулан түгээх ажлыг гүйцэтгэж, мах бэлтгэх төв нь жилд 259,8 тн маханд шинжилгээ хийж, 4500-4600 орчим бод, бог нядлах үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Тус ОНӨААТҮГ нь 2015 онд 528233,3 мянган төгрөгийн орлого олж, 582868,4 мянган төгрөгийн зардал гарган 54635,1 мянган төгрөгийн алдагдалтай ажиллажээ.

Тайлант онд авлага 54770,2 мянган төгрөгөөр, өглөг 81375,7 мянган төгрөгөөр тус тус өссөн бөгөөд 15697,1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 257231,2 мянган төгрөгийн нүүрс, шатахуун, 39217,9 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, бусад хангамжийн материал худалдан авсан байна.

2016 оны 1-р улирлын байдлаар 268400,5 мянган төгрөгийн орлого, үндсэн хөрөнгө худалдан борлуулсны олз 1030,8 мянган төгрөг бүртгэгдэж, 218130,6 мянган төгрөгийн зардал гарган 51300,7 мянган төгрөгийн ашигтай ажилласан бөгөөд авлага 96492,9 мянган төгрөгөөр, өглөг 39494,5 мянган төгрөгөөр өсчээ.

Тус ОНӨААТҮГ-ын 1-р гарын үсгийг захирал Т. Эрдэнэтуяа 2015 оны 12-р сарын 05-ны өдөр хүртэл, түүнээс хойш захирал Д.Отгонбаатар, 2-р гарын үсгийг нягтлан бодогч П.Одончимэг 2015 оны 05-р сарын 15-ны өдөр хүртэл, нягтлан бодогч Б.Жаргалтулга 12-р сарын 05-ны өдөр хүртэл, нягтлан бодогч П.Одончимэг 2016 оны 02-р сарын 04-ны өдөр хүртэл, түүнээс хойш нягтлан бодогч Ц.Дэлгэрцэцэг нар тус тус зурж, хөрөнгийг захиран зарцуулж ирсэн байна.

ГУРАВ. АУДИТЫН ДҮН

1. Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ-ын удирдлага нь хуулийн дагуу холбогдох албан тушаалтнуудтай гэрээ байгуулж, дүгнүүлэлгүйгээр үйл ажиллагаа явуулж иржээ.

1.1 Ус дамжуулан түгээх тусгай зөвшөөрөлгүйгээр УБТЗ-ийн ЭХУХ-ийн 1-р анги болон Спирт бал бурам ХХК-ны хэрэглэгчдийн усны төлбөрийн орлогыг нь цуглуулан авч, тус байгууллагуудад өгөх үүрэг хүлээсэн байна.

Сэлэнгэ-Зүүнхараа ОНӨААТҮГ-аар нь 2006 оны 4-р сард байгуулагдан улсын бүртгэлд бүртгэгдсэн боловч Мандал сумын ИТХ-ын 2013 оны 12-р сарын 20-ны өдрийн 45 тоот тогтоолоор албан ёсоор байгуулж, байгууллагын дүрмийг баталсан бөгөөд Мандал сумын ИТХТ-ийн 2015 оны 10-р сарын 06-ны өдрийн 72 тоот тогтоолоор тус үйлдвэрийн газрын дүрмийг шинэчлэн баталсан байна.

Уг шинэчлэгдсэн дүрмээр дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар тогтоосон байна. Үүнд:

- Дулаан үйлдвэрлэх, түгээх, хэрэглээний цэвэр ус дамжуулан түгээх
- Сантехникийн болон бусад төрлийн техник тоног төхөөрөмж засварлах, төлбөрт үйлчилгээ үзүүлэх
- Орон сууц ашиглалт, нийтийн аж ахуйн үйлчилгээ, инженерийн байгууламжид мэргэжлийн байгууллагын үйлчилгээ үзүүлэх

- Хүнсний хэрэгцээнд шинжилгээнд хамрагдсан мах, махан бүтээгдэхүүн бэлтгэх, худалдаалах, нөөцлөх
- Авто тээвэр, бусад төрлийн хүнд машин механизмаар төлбөртэй үйлчлэх
- Гадаад болон дотоод худалдаа эрхлэх
- Өөрийн эзэмшлийн хөрөнгө болон ажил үйлчилгээг бусдад түрээсээр ашиглуулах зэрэг болно.

Тус үйлдвэрийн газрын дүрмийн 3.1.3-д “*үйлдвэрийн үйл ажиллагааны үр дүнд олсон ашгаас хууль тогтоомжийн дагуу зохих татвар төлж, ашгийн 30 хувийг орон нутгийн төсөвт, 70 хувийг үйлдвэрийн газар захиран зарцуулах, тайлагнах*” гэж заасан байгаа нь ТБОНӨ-ийн тухай хуулийн 21¹.2.5¹, Төсвийн тухай хуулийн 23.9.1² дах заалтуудтай нийцэхгүй байна.

Сэлэнгэ аймгийн Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс дулаан үйлдвэрлэх, түгээх, дулаанаар зохицуулалттай хангах тусгай зөвшөөрлүүдийг 2014 оны 04-р сарын 15-ны өдрөөс 5 жилийн хугацаатай олгожээ.

Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ нь өөрийн зуухнаас 66 аж ахуйн нэгж, 90-ээд айл өрхийг дулаанаар хангахын зэрэгцээ УБТЗ-ын ЭХУХ-ын 1-р ангийн цэвэр ус, СББ ХХК-ны дулаан, халуун, хүйтэн усыг Тост өргөө хотхоны 100-н өрх болон 10-н аж ахуй нэгжид дамжуулан түгээх ажлыг гүйцэтгэж, мах бэлтгэх төв нь жилд 259,8 тн маханд шинжилгээ хийж, 4588 бод, бог нядлах үйлчилгээ үзүүлэн ажилласан байна.

Ус дамжуулан түгээх тусгай зөвшөөрөлгүйгээр УБТЗ-ын ЭХУХ-ийн 1-р анги болон Спирт бал бурам ХХК-ны үйлчилгээг дамжуулан түгээж хэрэглэгчдээс төлбөрийг нь цуглуулан авч, тус байгууллагуудад шилжүүлэх үүрэг хүлээсэн байгаа нь Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 12.1³ дэх заалтыг зөрчсөн үйлдэл болжээ.

Спирт бал бурам болон УБТЗ-ийн ЭХУХ-ийн 1-р анги нь дулаан, усны төлбөрийг төлөгдсөн эсэхээс үл хамааран бөөн дүнгээр нэхэмжилдэг, нөгөө талаас айл, өрх албан байгууллага нь ус, дулааны төлбөрийг цаг хугацаандаа төлдөггүйгээс тус үйлдвэрийн газрын авлага, өглөг хий өсч, үйл ажиллагаагаа хэвийн явуулахад хүндрэл учруулж байна.

1.2 Үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөг хуулийн хугацаанд батлуулаагүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78⁴.2.2⁵, 19.1⁶ дэх заалтын дагуу Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ-ын дарга нь аймгийн ОНӨАлбатай гэрээ байгуулан,

¹ Төсөвт оруулахаар төлөвлөсөн ногдол ашиг

² Орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн орон нутгийн өмчид ногдох хувьцааны ногдол ашиг

³ Хот, суурины ус хангамж, ариутгах татуургыг шинээр барьж байгуулах болон түүний ашиглалт, засвар үйлчилгээг Зохицуулах зөвлөлөөс олгосон тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд эрхлэн гүйцэтгэнэ.

⁴ Орон нутгийн өмчийн талаарх Засаг даргын бүрэн эрх

Мандал сумын Засаг даргаар батлуулан ажиллах ёстой атал 2015 онд тус үйлдвэрийн газрын даргаар ажиллаж байсан Т.Эрдэнэтуяа нь гэрээ байгуулалгүйгээр, урсгалаараа үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Тус үйлдвэрийн газрын дарга Т.Эрдэнэтуяа нь өндөр насны тэтгэвэрт гарсан тул 2015 оны 12-р сарын 5-нд тус үйлдвэрийн газрын даргаар Д.Отгонбаатар томилогдон 2016 оны 1-р сарын 02-ны өдөр аймгийн ОНӨАлбатай гэрээ байгуулан, Мандал сумын Засаг дарга Н.Нямдаваагаар батлуулан ажиллаж байна.

ОНӨААТҮГ нь байгууллагын хэтийн зорилгыг тусгасан стратеги төлөвлөгөөг өнөөг хүртэл боловсруулж батлуулаагүй бөгөөд 2015 оны төсөв, төлөвлөгөөг он дуусч байхад буюу 2015 оны 10-р сарын 08-ны өдөр, 2016 оны төсөв, төлөвлөгөөг 2016 оны 4-р сарын 07-ны өдөр тус тус батлуулан ажиллажээ.

Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ нь дээр дурдсанчлан 2015, 2016 оны зарцуулалтын төсвийг оройтож батлуулсан нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21¹.2.1⁷, 24.1⁸ дах заалтуудыг зөрчсөн байна.

Мандал сумын ИТХТ-ийн 2016 оны 4-р сарын 07-ны өдрийн 19 тоот тогтоолоор Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ-ын 2015 оны үйл ажиллагааг хангалтгүй гэж дүгнэн, шинээр томилогдсон дарга Д.Отгонбаатарт ажил сайжруулах үүрэг өгсөн байна.

1.3 Санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хийгдэж байгаа боловч үр нөлөө багатай байна.

Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ-ын үйл ажиллагаанд Сэлэнгэ аймгийн МХГ-ын байгаль орчин, хэмжилзүй, хөдөлмөрийн аюулгүй байдлын улсын байцаагч нар тус тусын чиглэлээр хяналт хийж зөвлөмж өгснийг зохих хэмжээнд хэрэгжүүлэн ажилласан бөгөөд 2013, 2014 оны санхүүгийн үйл ажиллагаанд нь аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2015 оны 12-р сард шалгалт хийж ямар нэгэн зөрчил илрүүлээгүй бөгөөд *"Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ нь Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүрэг, зорилтыг ханган биелүүлсэн, тус байгууллагын удирдлага, санхүү бүртгэлийн ажилтан нар нь анхан шатны баримт бүрдлийг хангаж, нягтлан бодох бүртгэлийн дэлгэрэнгүй журналыг хөтөлсөн, төрийн өмч хөрөнгийг данс бүртгэлд үнэн зөв илэрхийлэн зориулалтаар нь үр дүнтэй зарцуулсан байна"* гэж дүгнэсэн байгаа нь бодит байдалтай нийцэхгүй байна.

Мандал сумын ИТХ-ын 2015 оны 9-р сарын 09-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор тус үйлдвэрийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих шийдвэр гаргасны дагуу Мандал сумын Засаг даргын 2015 оны 10-р сарын 13-ны өдрийн 616 тоот захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй комисс томилогдон ажилласан байна. Шалгалтаар :

- Хуулийн хугацаанд сумын ИТХ-аар орлогыг нэр төрлөөр, зардлыг зүйл ангиар хэлэлцүүлэн, батлуулж, мөрдлөг болгон ажилладаг болох,

⁵ Орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн эрх баригчийг томилох

⁶ Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захирлыг томилохдоо гэрээ байгуулна.

⁷ Байгууллагын 3 жилийн хэтийн зорилт

⁸ Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар өөрийн чиг, үүрэг зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг санхүүгийн жил эхлэхээс 3 сарын өмнө гаргаж, Төрийн өмчийн хороо, Сангийн ямаар зардлын дээд хязгаарыг батлуулна.

- Их хэмжээний бэлэн мөнгөний гүйлгээ хийхгүй байх, халаалт, ус болон бусад орлогыг аль болох дансаар шилжүүлэг хийлгэн гүйцэтгэдэг байх,
- Ажлын төлөвлөгөө гаргаж удаан хугацаагаар дансанд бүртгэгдсэн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах,
- Ажиллагсдын цалин хөлсийг нэмэгдүүлэх, нийгмийн асуудлыг шийдвэрлэх тал дээр онцгой анхаарах,
- 2014 оны ашгийн 30 хувь болох 3500,0 мянган төгрөг, 2015 оны эхний хагас жилийн ашгийн 30 хувь болох 700,0 мянган төгрөг зэрэг нийт 4200,0 мянган төгрөгийг төрийн сангийн 130400955 тоот дансанд 2015-11-15-ны өдрийн дотор төвлөрүүлэх ,
- Орлогод аваагүй хөрөнгийг тайлан бүртгэлд бүрэн тусгах, хөрөнгө актлахдаа сумын удирдлага болон өмч хамгаалах комиссоос зөвшөөрөл авч шийдвэр гаргуулсан байх зэрэг зөвлөмж өгснөөс “ *ашгийн 30,0 хувийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэх* ” гэсэн хууль бус зөвлөмжөөс бусад нь бодит байдалд нийцсэн, тус үйлдвэрийн газрын санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах үр нөлөө бүхий ач холбогдолтой болсон байна.

Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6.7.1 дэх заалтын дагуу тус ОНӨААТҮГ-ын дарга Д.Отгонбаатар нь байгууллагын өдөр тутам тавих дотоод хяналтыг зохион байгуулснаар нягтлан бодогч П.Одончимэг нь дарга Д.Отгонбаатарын гарын үсэг зурж үлдээсэн баримтыг ашиглан 2015 оны 12-р сард Хангалуун хараа ХХК-ны дансанд 5000,0 мянган төгрөг, 2016 оны 1-р сард Магнай дэлгэрэх ХХК-ны дансанд 4500,0 мянган төгрөгийг нүүрсний үнэ гэж шилжүүлэн авсан зөрчил илэрсэн учир П.Одончимэгийг үүрэгт ажлаас нь чөлөөлж 2016 оны 2-р сард дээрх хөрөнгийг нөхөн төлүүлж, байгууллагыг хохиролгүй болгосон байна.

2. ОНӨААТҮГ-ын орлого, зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, тодорхой бус авлагуудыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулан, хуулийн байгууллагад шилжүүлэн авлага барагдуулах шаардлагатай байна.

2.1 Үйл ажиллагааны орлогыг үндэслэл муутай төлөвлөсөн бөгөөд төвлөрсөн орлогыг зөрүүтэй тайлагнасан байна.

Тус ОНӨААТҮГ нь 2015 онд 528233,3 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, 582868,4 мянган төгрөгийн зардал гарган 54635,1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан гэж тайлагнасан бол 2016 оны 1-р улирлын байдлаар 268400,5 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж, үндсэн хөрөнгө худалдан борлуулсны 1030,8 мянган төгрөгийн олз бүртгэн, 218130,6 мянган төгрөгийн зардал гаргаж 51300,7 мянган төгрөгийн ашигтай ажилласан гэж тайлагнажээ.

Тус үйлдвэрийн газрын 2015, 2016 оны 1-4 сарын орлогын төлөвлөлт, гүйцэтгэлийг авч үзвэл:

/мянган төгрөгөөр/

№	Орлогын төрөл	2015 ОН			2016 ОНЫ 1-4 САР	
		төлөвлөгөө	гүйцэтгэл	Гүйцэтгэлийн аудитаар	төлөвлөгөө	гүйцэтгэл
1	Халаалтын орлого	422772.7	438238	438238	176,027.5	277,178.1
2	Мах бэлтгэх төвийн орлого	23604.9	18757.7	20651	7,600.0	7,936.6
3	Зам засвар	30000	34268.8	30000		
4	Нүүрсний борлуулт		36817.8	52338.9		
5	Дулаан, ус дамжуулан түгээсний орлого			1998.9		7,297.8
6	Түрээсийн орлого			12272.5		205.5
7	Сантехникийн засвар, үйлчилгээний орлого					555.1
8	Бусад орлого		150.9	150.9		12.8
	Нийт орлогын дүн	476377.6	528233.2	555650.2	183627.467	293185.9

Орлогын төлөвлөлтөөс харахад 2015-2016 онуудад машин механизмын түрээсийн орлого, дулаан дамжуулан түгээсний орлого, сантехникийн засвар үйлчилгээний орлого зэрэг байгууллагын дүрмэнд заасан эрхлэх аж ахуйн орлогуудыг огт төлөвлөөгүй байсан бөгөөд 2016 онд халаалтын орлогыг үйлчлүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага, айл өрх бүрийн тоо, халаах талбайн хэмжээг үндэслэж бодитоор тооцож төлөвлөлгүйгээр өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн төлөвлөснөөс эхний 4 сарын байдлаар 57,5 хувиар давж биелэсэн байна.

Бид аудитын явцад анхан шатны баримтад үндэслэн 2015 оны орлогын бүртгэлийг дахин тооцоолол хийж шалгахад мах бэлтгэлийн орлогыг 1893,3 мянган төгрөгөөр, нүүрс борлуулсны орлогыг 15521,1 мянган төгрөгөөр дутуу, зам засварын орлогыг 4268,8 мянган төгрөгөөр илүү бүртгэж, дулаан, ус дамжуулсны 1998,9 мянган төгрөгийн, машин механизм түрээслүүлсний 12272,5 мянган төгрөгийн орлогыг бүртгэлд огт тусгаагүйгээс орлогыг нийт 27417,0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байлаа.

Аудитын явцад орлогын гүйцэтгэлтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- 30000,0 мянган төгрөгөөр гэрээ хийгдэж, санхүүжүүлсэн зам засварын ажлыг **4268,8 мянган** төгрөгөөр санхүүгийн тайланд илүү тусгасан байна. Уг ажлын гэрээний үнэ 19764,7 мянган төгрөгийг 2015 онд, 10235,3 мянган төгрөгийг 2016 онд санхүүжүүлсэн байна.
- 2015 оны 11-р сард гэрээ байгуулсан Спирт бал бурам ХХК-ны хариуцаж байгаа Тост өргөө хотхоны дулаан, усны төлбөрийг дамжуулан борлуулсны орлого **1998,9 мянган** төгрөг, 2016 оны **7297,8 мянган** төгрөгийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

- 2015 онд автогрейдер, зуурагч машин зэрэг машин механизмыг иргэн, хуулийн этгээдэд түрээслүүлсэн анхан шатны баримт болох гэрээ байгуулаагүй, машинуудыг хүлээлгэн өгсөн, хүлээн авсан цагийн бүртгэл, тооцоо нийлсэн акт зэрэг анхан шатны баримтгүйгээр **12272,5 мянган** төгрөгийн орлогыг бүртгэж, авлага хий үүсгэсэн байна.
- Мах бэлтгэх төвийн орлогод тухай бүр хяналт тавиагүй, өдөрт хэдэн мал нядалгаанд орж, шинжилгээнд хамрагдсан талаарх бүртгэл тооцоо үйлдээгүй бөгөөд сарын эцэст бөөн дүнгээр касс болон харилцахад орлого авсан байгаа нь төвлөрсөн орлогыг касс харилцахад дутуу төвлөрүүлэх, мөнгөн хөрөнгө ашиглагдан шамшигдах эрсдлийг үүсгэж байна.

2.2 Төвлөрсөн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан бөгөөд зардлын бүртгэлийн үйл ажиллагаанд их хэмжээний зөрчил оршиж байна.

Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ нь 2015 онд 528233,3 мянган төгрөгийн орлого олж, 582868,4 мянган төгрөгийн зардал гарган 54635,1 мянган төгрөгийн алдагдалтай, 2016 оны 1-р улирлын байдлаар 268400,5 мянган төгрөгийн орлого олж, 218130,6 мянган төгрөгийн зардал гарган, 1030,8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө данснаас хассаны олз бүртгэж, 51300,7 мянган төгрөгийн ашигтай ажилласан гэж тайлагнасан байна.

Мандал сумын ИТХТ нь 2015 оны 10-р сард 2015 оны төсвийг, 2016 оны 4-р сард 2016 оны төсвийг дараах байдлаар баталсан байна. Үүнийг хүснэгтээр үзүүлбэл:

/мянган төгрөгөөр/

№	Орлого, зарлагын ангилал	2015 он				2016 оны 1-4 сар		
		Уурын зуух	Зам засвар	Мах бэлтгэх төв	Нийт дүн	Уурын зуух	Мах бэлтгэх төв	Нийт дүн
1	Борлуулалт, ажил үйлчилгээний орлого	422,772.7	30,000.0	23,604.9	476,377.6	528,082.4	22,800.0	550,882.4
2	Цалин	153,435.9	6,064.8	34,146.0	193,646.7	182,495.0	35,388.0	217,883.0
3	НДШ	20,648.8	788.4	4,439.0	25,876.2	24,473.1	4,684.7	29,157.8
4	Цахилгаан	16,322.6		1,561.5	17,884.1	24,875.0	1,052.0	25,927.0
5	Нормын хувцас	3,844.0		740.0	4,584.0	3,332.0	740.0	4,072.0
6	Цэвэрлэгээ	242.3		1,732.0	1,974.3	517.0	1,570.8	2,087.8
7	Шатахуун	22,631.2	32,254.8	2,533.3	57,419.3	22,954.0	2,166.4	25,120.4
8	Түүхий эд материал	119,595.6		-	119,595.6	179,840.4	-	179,840.4
9	Бичиг хэрэг	577.5		684.0	1,261.5	712.5	440.0	1,152.5
10	Томилолт	1,146.0		350.0	1,496.0	1,146.0	350.0	1,496.0
11	Элэгдлийн зардал							
12	урсгал засвар	7,792.9	2,800.0		10,592.9			
13	ХО, их засвар	16,257.1		736.8	16,993.9	44,000.0	-	44,000.0
14	Зардлын дүн	362,493.9	41,908.0	46,922.6	451,324.5	484,345.0	46,391.9	530,736.9
15	Ашиг, алдагдал	60,278.8	(11,908.0)	(23,317.7)	25,053.1	43,737.4	(23,591.9)	20,145.5

Тус үйлдвэрийн газрын төсөвлөлтөөс харахад элэгдлийн зардлыг огт тооцоолоогүй бөгөөд зам засварын ажил, мах бэлтгэлийн төвийн алдагдлыг халаалтын ашгаас санхүүжүүлнэ гэж төлөвлөжээ.

Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ нь 2015 онд 54635,1 мянган төгрөгийн алдагдалтай ажилласнаар тайлагнасан боловч гүйцэтгэлийн аудитын явцад анхан шатны баримт, зардлын зарцуулалтанд үндэслэн орлого, зарлагыг дахин тооцоолон үзэхэд ашигтай ажилласан байлаа. Дахин тооцоолсон дүнг хүснэгтээр харуулбал:

№	Орлого, зарлагын ангилал	2015 он			2016 оны 1-4 сар		
		Уурын зуух	Мах бэлтгэх төв	Нийт дүн	Уурын зуух	Мах бэлтгэх төв	Нийт дүн
1	Борлуулалт, ажил үйлчилгээний орлого	438,238.00	20,651.00	458,889.00	277,178.10	7,936.60	285,114.70
2	Цалин	134,365.70	33,959.20	168,324.90	63,286.60	12,083.80	75,370.40
3	НДШ	17,467.60	4,414.70	21,882.30	8,227.30	1,570.90	9,798.20
4	Цахилгаан	16,494.00	1,064.60	17,558.60	12,174.20	606.6	12,780.80
5	Нормын хувцас	2,736.20		2,736.20	1,363.60		1,363.60
6	Сэлбэг/Хангамж	1212.4	820	2,032.40	2,116.10	707.6	2,823.70
7	Шатахуун	17,548.10	2,745.50	20,293.60	6,137.50	576	6,713.50
8	Түүхий эд материал	144,765.20	510.7	145,275.90	86,792.90	656.4	87,449.30
9	Тээврийн зардал	12,201.20		12,201.20			0.00
10	Бичиг хэрэг	590.8	270	860.80	632.2		632.20
11	Томилолт	751.5		751.50	916.1		916.10
12	Шуудан холбоо	921.10	80.90	1,002.00	130.4		130.40
13	Элэгдлийн зардал	42,892.60	3431.2	46,323.80	13,873.20	1,441.30	15,314.50
14	Бусад зардал	2,455.00	890	3,345.00	9,332.70	50.6	9,383.30
15	урсгал засвар	8,300.00		8,300.00	5383.8	188	5,571.80
	Зардлын дүн	402,701.40	48,186.80	450,888.20	210,366.60	17,881.20	228,247.80
	Ашиг, алдагдал	35,536.60	-27,535.80	8,000.80	66,811.50	-9,944.60	56,866.90

Тус байгууллагын нягтлан бодогч бүртгэл тайланг үнэн зөв хөтлөөгүй, зардлын зарцуулалт нь анхан шатны баримтаар нотлогдохгүй, авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, материалын тайланг стандартын дагуу хөтлөөгүй, нүүрс, үртсийг сарын эцэст бөөн дүнгээр зарлагадсан, мах бэлтгэх төвийн орлогод өдөр тутам хяналт тавиагүй зэрэг шалтгаануудын улмаас санхүүгийн тайланг алдагдалтай тайлагнасан зэргээр тус үйлдвэрийн газрын нягтлан бодох бүртгэл хөтлөлт, хөрөнгийн заоцуулалтад бүртгэлээр тавих хяналт туйлын хангалтгүй байна. Тухайлбал:

2015 онд хөрөнгийн зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн 25.10, ТБОНӨ-ийн тухай хуулийн 30.3 дах заалтуудыг зөрчиж 2015 оны 2-р сард Мандал сумын харьяалалгүй ахмадуудад хүндэтгэл үзүүлэхэд 323,2 мянган төгрөг, байгууллагын нэрэмжит бөхийн тэмцээнд 1300,0 мянган төгрөг, 3-р сард Зүүнхараа хотын нэгдсэн дулааны шугамын зураг, төсвийн магадлагааны үнэ 3002,7 мянган төгрөг, “Мандал-2015” календарийн үнэ 3150,0 мянган төгрөг зэрэг нийт 7775,9 мянган төгрөгийн хандив өгсөн,
- 2016 онд “Ус бол цэвэр хараа гол” арга хэмжээнд 292,0 мянган төгрөг, “РИО-2016” олимпын их наадамд 100,0 мянган төгрөгийн хандив өгсөн,
- Мандал сумын ЗДТГ-ын газарт 923,9 мянган төгрөгийн шатахууны хандив олгосон байна.

2016 онд хөрөнгийн зарцуулалттай холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Мандал сумын Засаг даргын 2015 оны 12-р сарын 05-ны өдрийн 70 тоот захирамжаар үйлдвэрийн дарга Д.Отгонбаатарыг сарын 790,5 мянган

төгрөгөөр цалинжуулахаар тогтоосон атал 2016 оны 5-р сар хүртэл 1300,0 мянган төгрөгөөр цалинжуулж 2454,8 мянган төгрөгийг илүү олгосон байна.

- Слесарь Д.Олонжавын амралтын цалинг 487,5 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.
- Дарга Д.Отгонбаатарын “Төрийн удирдлага-ХАБЭА” мэргэшүүлэх сургалтын төлбөрт хууль, эрх зүйн үндэслэлгүйгээр 1500,0 мянган төгрөг төлсөн байна.
- Нийгмийн даатгалын тайлангийн 2015 оны эхний өглөгийн үлдэгдэл 8218,3 мянган төгрөгийг тусгаагүйгээс 2016 оны 4-р сарын эцсийн байдлаар өглөгийн үлдэгдэл 5987,3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.

2015 онд Мандал сумын ЗДТГ-аас зарласан “Гэр хорооллын гудамжны зам талбайг сайжруулах” ажлын тендерт шалгарч, 30000,0 мянган төгрөгийн ажлын гэрээ байгуулсан боловч гарсан зардлын дүн болох 37683,5 мянган төгрөгийн орлого бүртгэж, тайлант онд орсон 19764,7 мянган төгрөгийн орлогыг хасч, жилийн эцэст 17918,8 мянган төгрөгийн ЗДТГ-аас авах авлага үүсгэсэн байна.

Зам засварын ажлын гүйцэтгэлийн баримт материалаас үзэхэд зардлын 73 хувийг шатахууны зардал эзэлж байгаа боловч энэ нь анхан шатны баримтаар нотлогдохгүй, өөрөөр хэлбэл энэ хэмжээний шатахуун гарсан эсэх нь нотлогдохгүй байхад уг ажилд 37683,5 мянган төгрөг зарцуулсан гэж бүртгэсэн байна.

/мянган төгрөгөөр/

№	Зардлын төрөл	Мөнгөн дүн	эзлэх хувь
1	Зам тэгшлэх ажил- Грейдерийн шатахуун	20205,1	53.6
2	Хайрга буулгах ажлын шатахуун	7274,9	19.3
3	Хайрга буулгах жолоочийн ажлын хөлс	4153,5	11.0
4	Туушин хараа ХХК-экскаваторын ажлын хөлс	4800,0	12.7
5	Грейдерийн тосны шүүр, тос, хутга	1250,0	3.3
	Нийт дүн	37683,5	100

Ингэж анхан шатны баримтын бүрдэлгүй ажил гүйлгээг бүртгэл, тайланд тусгасан, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй авлага өглөгийг тайлагнасан нь МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1⁹, 7.1¹⁰, 9.1¹¹ дах заалтуудыг зөрчсөн байна.

2.3 Авлага, өглөгийг үүссэн тухай бүр нь бүртгэлд тусгаагүй байна.

Тус үйлдвэрийн газар нь 2015 оны эхэнд халаалтын авлага 31561,9 мянган төгрөг, бусад авлага 30716,9 мянган төгрөг, Шивээ овоо ХХК-нд 4931,0 мянган төгрөгийн, татварт 4320,6 мянган төгрөгийн өглөгийн эхний үлдэгдэлтэй тайлагнагдсан бол тайлант онд авлага 54770,2 мянган төгрөгөөр, өглөг 81375,7 мянган төгрөгөөр өсчээ.

⁹ Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккрузал сууриар хөтөлнө.

¹⁰ “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”

¹¹ “Хөрөнгө өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана”

2015 оны жилийн эцэст тайлагнагдсан **авлагуудыг нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй дараах зөрчлүүд илэрлээ**. Үүнд:

- Аж ахуйн нэгж, байгууллага иргэдэд машин механизм түрээслүүлсний 12272,5 мянган төгрөгийн авлага нь түрээсийн гэрээ, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй байна. Үүнийг тодруулбал: ОТЗ ХХК-аас 3222,5 мянган төгрөг, Спиртийн шинэ цэцэрлэг 2400,0 мянган төгрөг, Ц.Эрдэнэхүү 3750,0 мянган төгрөг, Д.Амгалан 1050,0 мянган төгрөг, Ганжигүүр 950,0 мянган төгрөг, Г.Ганчимэг 900,0 мянган төгрөг.
- Мандал сумын ЗДТГ-аас авах зам засварын ажлын 17918,7 мянган төгрөгийн авлага нь тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй,
- Мах бэлтгэх төвийн хөргөгчийг иргэдэд зээлээр худалдсан гэх 1920,0 мянган төгрөгийн авлага нь зээлийн гэрээ, үлдэгдлийн тооцоо, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй,
- ОТЗ компаниас авах халаалтын 15500,0 мянган төгрөг, сумын ЗДТГ-аас авах өвсний фондын 2815,5 мянган төгрөгийн авлагууд нь мөн тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй, бодитоор оршиж байгаа эсэх нь тодорхой бус байна.

Өглөгийг анхан шатны баримт, тооцоо нийлсэн акттай тулган баталгаажуулахад дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтаар 2015 оны эхэнд Шивээ овоо ХК-д 27813,2 мянган төгрөгийн өртэй байсан боловч санхүүгийн тайланд 4931,0 мянган төгрөгийн өглөг тайлагнасан байна. Үүнийг нягтлан бодогчоор ажиллаж байсан П.Одончимэгээс тодруулахад *"Энэ 27813,2 мянган төгрөгийн өглөгийг хүлээн зөвшөөрч байна. Дарга Т.Эрдэнэтуяа 2015 оны балансыг ашигтай гаргаж өгөөч гэж гуйсан учраас өглөгөө хасч тайлагнасан"* гэсэн тайлбарыг өглөө.
- Шивээ овоо ХХК-иас худалдан авсан нүүрсний үнийг гэрээний дүнгээс илүү үнээр тооцож, тээврийн зардлыг тусад нь бүртгээгүйгээс 2015 оны жилийн эцсийн тооцоо нийлсэн акт 2793,0 мянган дүнгээр зөрүүтэй буюу өглөг илүү тайлагнасан байлаа.

Авлага, өглөгийг үүссэн тухай бүр анхан шатны баримтыг үндэслэн бүртгэлд тусгаагүй, тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1, 9.1, 19.1.4, 19.1.5, 20.1.4 дэх заалтуудыг зөрчиж байгаа бөгөөд хөрөнгө эзэнгүйдэх, компаний мөнгөн хөрөнгийн эргэлт саарах улмаар эргэлтийн хөрөнгө дутагдах нөхцөл байдлыг үүсгэж байна.

3. Гол нэрийн материалын зарцуулалтанд тавих хяналт сул байгаагаас 27571,5 мянган төгрөгийн нүүрсний зарцуулалт тодорхойгүй, зам засварын ажилд зарцуулсан 24612,5 мянган төгрөгийн шатахууны зардлын баримтын бүрдэл дутуу байна.

3.1 Худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй байна.

МУ-ын ТБОНӨХБАҮХАТ хуулийн 21.1 дэх “Захиалагч тендерийн урилгыг үндэсний хэмжээний өдөр тутмын сонин, хэвлэл мэдээллийн бусад хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчин нүүрс нийлүүлэх компанийг нээлттэй тендер зарлалгүйгээр, Шивээ овоо ХК-тай шууд гэрээ байгуулан 156417,0 мянган төгрөгийн, Идэр хараа, Туушин хараа, Тунгалаг арвижих, Дерватив зэрэг аж ахуйн нэгжээс 23504,0 мянган төгрөгийн нүүрсийг шууд худалдан авсан байна.

2015 онд Шунхлай петролиум ХХК-аас 22719,1 мянган төгрөгийн, Магнай трейд ХХК-аас 24627,9 мянган төгрөгийн шатахуун, хувь хүнээс 29516,1 мянган төгрөгийн үртсийг харьцуулалтын арга хэрэглэлгүй шууд гэрээ байгуулан худалдан авсан зэрэг нь МУ-ын ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 8.1.1¹², ЗГ-ын 2013 оны 68 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгоход баримтлах босго үнэ”-ийн 2 дахь¹³ заалтыг тус тус зөрчсөн байна.

3.2 Хөрөнгө нөөцийн зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.

Тус ОНӨААТҮГ нь 2015 онд 15697,1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 255949,4 мянган төгрөгийн нүүрс, шатахуун, 39217,9 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, бусад хангамжийн материал худалдан авсан бол 2016 оны эхний 4 сард 1130,9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 64799,4 мянган төгрөгийн нүүрс, шатахуун, 6460,1 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, бусад хангамжийн материал худалдан авсан байна.

Нягтлан бодох бүртгэлийн программд худалдан авсан түүхий эд материалын үнийг бэлтгэн нийлүүлэгчийн падааны дүнгээс зөрүүтэйгээр оруулж байгаагаас материалын тайлангийн дүн мөнгөн хөрөнгийн зарцуулалтын тайлан, тооцоо нийлсэн актын дүнгээс зөрж байна.

2015 онд ашиглаж байсан санхүүгийн программ нь зөвхөн журнал, ерөнхий дэвтрийг боловсруулан гаргаж, санхүүгийн тайланг боловсруулж гаргахгүй байгаа нь санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдлийг үүсгэж байгаа учир 2016 онд нягтлан бодох бүртгэлийн Венеца программыг худалдан авч, бүртгэл тайлангаа хөтөлж байна.

Тус үйлдвэрийн газрын нягтлан бодогчдын мэргэжлийн мэдлэг хангалтгүй, бүртгэлийн программыг бүрэн эзэмшээгүйгээс хөрөнгийн үлдэгдлүүд балансын дүнгээс зөрөх, авлага өглөгийг зөрүүтэй илэрхийлэх, түүхий эд материалын худалдан авсан үнийг буруу оруулах, журнал, ерөнхий дэвтрийн дүн балансын дүнгээс зөрөх зэргээр холбогдох хууль, стандартыг зөрчиж байгаа нь хөрөнгө эзэнгүйдэх, ашиглан шамшигдах нэг нөхцөл болж, хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг алдагдуулж байна.

Тус үйлдвэрийн газрын түүхий эд материалын дийлэнх хувийг эзэлдэг гол нэрийн материалуудын 2015 оны худалдан авалт, зарцуулалтыг тодруулж үзвэл:

/мянган төгрөгөөр/

Материалын нэр	эхний үлдэгдэл	худалдан авалт	зарцуулалт	эцсийн үлдэгдэл
----------------	----------------	----------------	------------	-----------------

¹² Харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар

¹³ Шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаар бараа 10 сая төгрөг

Нүүрс	29145.6	179921	180238.6	28828
Үртэс	3964	29516	33480	0
Шатахуун	1876.4	46512.4	46936.5	1452.3
Нийт дүн		255949.4	260655.1	

2015 оны нүүрс, үртэсний зарцуулалтыг нарийвчлан авч үзвэл:

- Шивээ овоо ХК-иас бусад компаниас 1 тн нүүрсийг 50,0 мянган төгрөгөөр зарлагын падааныг үндэслэн орлого авсан боловч 399,7 тн буюу 19984,0 мянган төгрөгийн нүүрсний зарцуулалт тодорхойгүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.
- Оны эхний үлдэгдэл 50,0 мянган төгрөгийн нэгжийн үнэтэй 123 тн нүүрс, тайлант онд Шивээ овоо ХХК-иас худалдан авсан 33,2 мянган төгрөгийн нэгжийн үнэтэй 43,3 тн буюу нийт 7587,5 мянган төгрөгийн нүүрсний зарцуулалт тодорхойгүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй зэргээр нийт 27571,5 мянган төгрөгийн нүүрсний зарцуулалт тодорхойгүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.
- Жилд зарцуулсан 3132.5 тн нүүрсийг тус үйлдвэрийн газрын инженер техникийн ажилчдын гаргасан нормативт зарцуулалттай харьцуулж үзвэл 2697 тн буюу 435.5 тн нүүрс илүү зарцуулсан байна. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд өдөр тутам тавих дотоод хяналт хангалтгүйгээс нүүрс, үртэс зэрэг материалыг бөөн дүнгээр сарын эцэст зарлагдаж 14 хувиар буюу 16475.8 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гарган ажилласан байна.
- Зарлагын падаан, нэхэмжлэх зэрэг анхан шатны баримтгүйгээр Шивээ-овоо ХК-д төлбөр шилжүүлж ирсэн бөгөөд тус компаний журналыг, УБТЗ-ын тээврийн баримттай тулган баталгаажуулахад Шивээ овоо ХК-тай 1 тонн нүүрсийг 2015 оны 09 сарын 10-н хүртэл 25482 төгрөгөөр, түүнээс хойш 26642 төгрөгөөр худалдан авч, тээврийн зардлыг Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ хариуцахаар гэрээ байгуулсан боловч тээврийн зардлыг тухай бүрт нь хуримтлуулж бүртгэлгүйгээр, тогтмол дүнгээр тооцож 2015 оны 09 сарын 10-н хүртэл 33181 төгрөгөөр, түүнээс хойш 37832 төгрөгөөр тооцон бүртгэснээс шалтгаалан худалдан авалтын дүн 6430,3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан байна.
- Нүүрсний зардлын зарцуулалт 180238,6 мянган төгрөг бус 152667,3 мянган төгрөг байгаа бөгөөд үүнийг үйл ажиллагааны төрлөөр нь авч үзвэл:

/мянган төгрөгөөр/

Нүүрсний зардлын зарцуулалт	тоо хэмжээ	мөнгөн дүн	эзлэх хувь
Зууханд	3,132.5	111,287.1	72.9
МБТ	13.5	510.7	0.3
Борлуулалт	1,014.5	37,899.5	24.8
Ажилчдад	66.0	2,970.0	1.9
дүн	4,226.5	152,667.3	100.0

Эндээс харахад худалдан авсан нүүрсний 72,9 хувийг үндсэн үйл ажиллагаанд зарцуулж, 24,8 хувийг худалдан борлуулж, 1,9 хувийг ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зорилгоор үнэ төлбөргүй олгож, 0,3 хувийг мах бэлтгэх төвийн галлагаанд зарцуулсан байна.

2015 оны шатахууны зардлын зарцуулалтыг нарийвчлан авч үзвэл:

- Шатахууныг Шунхлай петролиум, Магнай трейд ХХК-аас А-80-г 1590, А-92-г 1790, дизель түлшийг 1830 төгрөгөөр худалдан авсан боловч санхүүгийн программд нэгжийн үнийг 1000 төгрөгөөр тооцож, тоо хэмжээг үнийн дүнд тааруулан шахаж оруулсан бөгөөд шатахууны тайланд урсгал засварын материалын орлого, зарлагыг тусгасан байлаа.
- Касс, харилцахын тайлангаас шатахууны зардлыг түүвэрлэн, шатахууны материалын тайлантай тулгаж үзэхэд нэгжийн үнийг 1000 төгрөгөөр оруулснаас орлого, зарлагын дүн зөрүүтэй, нийт дүнгээр нь тулган баталгаажуулахад 834,6 мянган төгрөгийн шатахууныг материалын тайланд дутуу орлого авч, зарцуулалт нь тодорхойгүй байлаа.
- Шатахууны зардлын зарцуулалтыг үйл ажиллагааны төрлөөр нь авч үзвэл:

/мянган төгрөгөөр/

Шатахууны зардлын зарцуулалт	мөнгөн дүн	эзлэх хувь
Уурын зуух	17548.1	37.5
Мах бэлтгэх төв	2745.5	5.9
Захиргаа аж ахуй	976.3	2.1
Мандал сумын ЗДТГ	923.9	2.0
Зам засварын ажил	24612.5	52.6
нийт дүн	46806.3	100.0

Эндээс харахад тус үйлдвэрийн газрын үндсэн үйл ажиллагаанд 37,5 хувь, үндсэн бус үйл ажиллагаа буюу алдагдалтай ажилласан зам засварын ажилд 52,6 хувь, бусад үйл ажиллагаанд 9,9 хувийг зарцуулсан байгаа нь удирдлагын зүгээс тавих хяналт сул, үйлдвэрийг удирдах бодлого, менежмент хангалтгүй байна.

Эдгээр зөрчлүүд нь МУ-ын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4.1.1¹⁴, 9.1¹⁵, 19.1.4¹⁶, 19.1.5¹⁷, 20.1.4¹⁸ дэх заалтуудыг зөрчиж байна.

¹⁴ Аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх

¹⁵ Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана.

¹⁶ Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах

¹⁷ Эд хөрөнгө, өр төлбөрийн хүчин төгөлдөр бус баримтаар ажил гүйлгээг бүртгэхгүй байх

¹⁸ хуурамч баримт бүрдүүлэн ажил гүйлгээг дансанд бичих

3.3 Эргэлтийн хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд зохион байгуулаагүй, үндсэн хөрөнгийг хувь хүний эзэмшилд улсын бүртгэлд бүртгүүлж, зарим хөрөнгийг санхүүгийн тайланд дутуу тусгасан байна.

Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ нь 2015 оны эхэнд 452813,2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй, 39169,0 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгөтэй байсан бол 2015 оны жилийн эцэст үндсэн хөрөнгийн тооллогыг хийж, зургаар баталгаажуулсан боловч мөнгөн хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийгээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2.2¹⁹, 70.2.4²⁰ дах заалтуудыг зөрчсөн байна.

Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, эзэмшилтэй холбоотой дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

- Бороо гоулд ХХК-ийн хандиваар 2006 онд Мандал сумын ЗДТГ-аас худалдан авах ажиллагааг зохион байгуулж худалдан авсан 30000,0 мянган төгрөгийн Мах бэлтгэх төвийн барилгын газрын гэрчилгээ тус ОНӨААТҮГ-ын нэр дээр байгаа боловч үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ нь иргэн Г.Буяннэмэхийн нэр дээр улсын бүртгэлд бүртгэлтэй,
- Аймаг хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр 2010 онд баригдсан махны зоорь нь улсын комисс хүлээж аваагүй гэдэг шалтгаанаар өнөөг хүртэл санхүүгийн тайланд тусгагдаагүй,
- Замын сангийн хөрөнгөөр худалдан авсан 50000,0 мянган төгрөгийн индүү, 49000,0 мянган төгрөгийн экскаватор, 35000,0 мянган төгрөгийн трактор зэрэг авто тээврийн хэрэгслүүдийн гэрчилгээг гаргуулахаар 2014 онд Сэлэнгэ аймгийн Автотээврийн албанд албан тоот, худалдах, худалдан авах гэрээнүүдийн хамт өгсөн гэх боловч өнөөг хүртэл гэрчилгээ нь гараагүй,
- 2014 оны 6-р сард бүртгэлд тусгасан 4076,3 мянган төгрөгийн усны машины авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь иргэн С.Сүхбаатар, 4200,0 мянган төгрөгийн хөргүүртэй машины авто тээврийн хэрэгслийн гэрчилгээ нь иргэн Ш.Өнөрбаярын эзэмшилд тус тус улсын бүртгэлд бүртгэгдсэн байна,
- Мандал сумын ИТХТ-ийн 2015 оны 79-р тогтоолоор 2012-2014 онд ашиглалтанд хүлээж авсан 91982,5 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхийн Тост өргөө хотхоны инженерийн шугам сүлжээг орлого авахыг зөвшөөрсөн байхад санхүүгийн тайланд тусгаагүй,
- 2016 оны хөрөнгийн тооллогоор 2015 оны 6-р сард хулгайд алдагдсан 1150,0 мянган төгрөгийн Асер зөөврийн компьютерийг актлах хөрөнгийн дүнд оруулан тооцсон,
- 2016 оны 2-р сард 4500,0 мянган төгрөгийн программ хангамж худалдан авсан боловч 1-р улирлын санхүүгийн тайланд тусгаагүй
- 2016 оны 4-р сард 417,9 мянган төгрөгийн зургийн аппарат худалдан аваад бараа материалд бүртгэсэн байлаа.

¹⁹ Түүхий эд материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа, боодлын тооллогыг улиралд 1 удаа

²⁰ Мөнгөн хөрөнгө, шатах, тослох материал болон жижиглэн худалдаалах газар-т байгаа бараа, са, боодлыг сар бүр

Дөрөв. Илрүүлсэн зөрчил

Хийж гүйцэтгэсэн аудитаар дараах зөрчлүүдэд акт, албан шаардлага бичигдлээ.

1. Акт:

- Тус үйлдвэрийн газрын дарга Д.Отгонбаатарын цалинг илүү тооцож олгосон 2454,8 мянган төгрөг,
- Слесарь Д.Олонжавын амралтын цалинг илүү тооцож олгосон 487,5 мянган төгрөг,
- Тушаал шийдвэр, хууль эрх зүйн үндэслэлгүйгээр үйлдвэрийн газрын дарга Д.Отгонбаатарын сургалтын төлбөрт 1500,0 мянган төгрөг төлсөн зэрэг **нийт 4442,3 мянган** төгрөгийн төлбөрийн акт,

2. Албан шаардлага:

- 2015 онд 7775,9 мянган төгрөгийн, 2016 онд 392,0 мянган төгрөгийн хандив өгсөн,
- Мандал сумын ЗДТГ-т 923,9 мянган төгрөгийн шатахуун олгосон,
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, тооцоо нийлсэн актаар баталгаажуулахгүй 50426,7 мянган төгрөгийн авлагыг баталгаажуулах, шаардлагатай бол хууль хяналтын байгууллагад шилжүүлэх,
- Шивээ овоо ХК-иас худалдан авсан нүүрсний үнийн дүнг залруулж 39650,6 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах,
- Зарцуулалт нь тодорхой бус 27571,5 мянган төгрөгийн нүүрсний зарцуулалтыг тодорхой болгож, холбогдох ажилтнуудаар тайланг гаргуулах,
- Материалын тайланд дутуу орлого авсан 834,6 мянган төгрөгийн, зам засварын ажлын 24612,5 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг тодорхой болгож, холбогдох ажилтнуудаар тайланг гаргуулах,
- Хувь хүний эзэмшилд бүртгэгдсэн 38276,3 мянган төгрөгийн үл хөдлөх хөрөнгө болон тээврийн хэрэгслийг үйлдвэрийн газрын эзэмшилд шилжүүлэх,
- Данс бүртгэлд байгаа 134000,0 мянган төгрөгийн өртөг бүхий тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгүүлэх,
- Худалдан авсан 4917,9 мянган төгрөгийн, хандив тусламжаар ирсэн 91982,5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлого авах,
- Нийгмийн даатгалын тайланд оны эхний үлдэгдэл өглөгийг тусгаагүйгээс 4-р сарын эцсийн байдлаар 5987,3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан алдааг залруулах зэрэг **нийт 427351,7 мянган** төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага бичигдлээ.

Тав. Дүгнэлт

- Үйлдвэрийн газрын стратеги, жилийн үйл ажиллагааг үндэслэлтэй төлөвлөөгүй, үйлдвэрийн удирдлагаас холбогдох албан тушаалтантай гэрээ байгуулаагүй зэргээр урсгалаараа үйл ажиллагаа явуулж ирсэн байна.
- Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ-ын удирдлага, менежмент, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа туйлын хангалтгүйгээс орлогоороо зарлагаа нөхөж, ашигтай ажиллах нөөц боломжийг алдсан байна.
- Үйлдвэрийн газрын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт үр нөлөө муутай байна.
- Хөрөнгө, мөнгөний зарцуулалт, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд их хэмжээний зөрчил оршиж байна.
- Худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулаагүй байна.
- Их хэмжээний үл хөдлөх хөрөнгө, тээврийн хэрэгсэл хувь хүний эзэмшилд улсын бүртгэлд бүртгэгдсэн байна.

Зургаа. Аудитын зөвлөмж

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Мандал сумын ИТХ-ын дарга болон Засаг дарга нарт:

- Сэлэнгэ-Зүүнхараа ОНӨААТҮГ-ын дүрмийн 3.1.3 дах заалтыг хуульд нийцүүлэн өөрчлөх.
- Үйлдвэрийн газрын үндсэн болон санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах.
- Үйлдвэрийн газрын үндсэн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг авч хэлэлцэн, төсөв, төлөвлөгөөг хуулийн хугацаанд багтаан баталж байх,
- Үйлдвэрийн газрын даргатай байгуулсан гэрээг тухай бүр нь дүгнэж, үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгч байх.

Сэлэнгэ Зүүнхараа ОНӨААТҮГ-ын дарга Д.Отгонбаатар-т:

- Спирт бал бурам болон УБТЗ-ийн ЭХУХ-ийн 1-р ангитай байгуулсан гэрээг дахин авч үзэж холбогдох хууль, журамд нийцүүлэх.
- Үйлдвэрийн газрын хэтийн зорилго, зорилтыг тодорхойлсон стратеги төлөвлөгөөг боловсруулан, хуулийн хугацаанд төсөв, төлөвлөгөөгөө батлуулан, сумын ИТХ болон аймгийн ОНӨА-нд ажлаа тайлагнан, дүгнүүлж ажиллах.
- Санхүүгийн болон нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулах.

- Зам засварын ажлын төсвийг мэргэжлийн төсөвчнөөр хийлгүүлж, мэргэжлийн инженерийг гэрээний үндсэн дээр ажиллуулан, үр ашгийг нэмэгдүүлэх
- Нүүрс, шатахуун зэрэг гол нэрийн материалуудын худалдан авалтыг хуулийн дагуу зохион байгуулах
- Нягтлан бодогчийн мэргэжлийн мэдлэгийг дээшлүүлэх, бүртгэлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.

Нягтлан бодогч Ц.Дэлгэрцэцэг-т:

- Байгууллагын төсвийг үндэслэлтэй төлөвлөж, орлого, зарлагын гүйцэтгэлд санхүүгийн шинжилгээ хийх
- Хөрөнгө, мөнгөний зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулж, НББ-ийн анхан шатны баримтуудыг стандартын дагуу хөтлөх, бүртгэлийн үйл ажиллагаанд НББОУС-ыг мөрдөх.
- Хөрөнгийн тооллогыг хуулийн хугацаанд хийж хэвших.
- Улсын бүртгэлийн гэрчилгээ нь хувь хүний нэр дээр байгаа хөрөнгүүдийг байгууллагын нэр дээр шилжүүлэх ажлыг зохион байгуулах
- Аймаг хөгжүүлэх сангийн эх үүсвэрээр 2010 онд баригдсан махны зоорийг холбогдох баримт материалыг бүрдүүлэн үндсэн хөрөнгөнд бүртгэх

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АУДИТОР

Ч.ЭНХТУЯА
Б.БАТМӨНХ
Ц.ОТГОНБАЯР